

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Уурхайн ашиглалтын худгуудад засвар үйлчилгээ хийх” гүйцэтгэгчийг сонгох” ЭТТ/201901208 дугаартай харьцуулалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минунаас өмнө цахим систем болох [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 10 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК Жигжиджав-8, Финанс төв, 5 давхар 503 тоот өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендertэй холбоотой бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,  
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160,  
Утас: 75055555-504, Факс: 70118464,  
Холбоо барих ажилтан: Д.Нямбаяр,  
[nyambayar.d@erdenestt.mn](mailto:nyambayar.d@erdenestt.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлэс бүрдэнэ:
    - (а) Унийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Унийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
    - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхийл байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал  
болгосон үнэ,  
түүнийг  
үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<p>Үнийн саналыг жишиг маягтын дагуу ирүүлэх</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>2. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг ижил төстэй ажил гүйцэтгэж байсан гэрээ, гэрээ дүгнэсэн акт, 5-аас доошгүй орд талбай дээр ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх</li> <li>3. Татварын газрын цахим тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойши хайдлаар ирүүлэх/</li> <li>4. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойши хайдлаар ирүүлэх/</li> <li>5. НӨАТ-ийн гэрчилгээний хуулбар</li> <li>6. Тухайн чиглэлээр ажил явуулж байсан талаархи компанийн танилцуулга</li> <li>7. Өрмийн мастер-1 хүн, туслах ажилчид-3 хүн байх ба дээрийн ажилчдын мэргэжлийн үнэмлэх, сертификаттай байх бөгөөд тухайн чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагтай, 1-аас доошгүй жил ажилласан гидрогеологич инженер-1 хүн байх</li> <li>8. Ажилчдын НД №8 маягт ирүүлэх</li> <li>9. Гүний худаг өрөмдөх, тоноглох, засвар үйлчилгээ хийх мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлтэй байх</li> </ol> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <i>[Усны тухай хуулийн 10.1.23-д заасан цооног өрөмдөх, худаг гаргах, усны барилга байгууламж барих, ашиглах судалгаа хийх, дүгнэлт гаргах зөвшөөрөлтэй байх.]</i></p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Тендерийг <a href="http://www.tender.gov.mn/">www.tender.gov.mn/</a> хаягаар хүлээн авна.</b></p> <p>Огноо: <b>2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв. “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Улаанбаатар-15160</b></p> <p>Огноо: <b>2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 10 минут</b></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бурдэнэ: <b>Багцгүй.</b>

# Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1. Зорилго:

Ажилчдын “Цанхи” хотхоны ахуйн ус хангамжийн зориулалтаар ашиглагдаж байгаа №4-р худгийг 2012 оны 12 дугаар сард 1л/с-ийн ундаргатайгаар гаргаж тоноглосон байдаг. Худгийн ашиглаж эхэлснээс хойш шүүрийн цувааг цэвэрлэх, лайдах ажил хийгдээгүй. Үүнээс болж худгийн ундарга багсах, мөн усны сэргэлт удааширч ашиглалтын үйл явцад асуудал үүсч байгаа тул зайлшгүй хийх шаардлагатай байна.

## 2. Үндсэн шаардлага:

*Нийлүүлэгчид тавигдах шаардлага:*

### 2.1 Гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлагын жагсаалт:

- Гүйцэтгэгч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна
- Компани нь 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, 5-аас доошгүй орд талбай дээр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх
- Техник, тоног төхөөрөмжүүд нь ямар нэг эвдрэл гэмтэлгүй, ажлын тасралтгүй, аюулгүй үйл ажиллагааг бүрэн найдвартай хангасан байх

### 2.2 Чанар, стандарт / хэрвээ олон улсад мөрдөгддөг стандарт байдаг бол тухайн стандартыг, монгол улсад мөрдөгдөж байгаа стандарт байдаг бол тухайн стандартыг заавал дурьдах/:

- Өрмийн мастер болон туслах ажилчид нь мэргэжлийн үнэмлэх, сертификаттай байх бөгөөд тухайн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай, 1-аас доошгүй гидрогеологич инженертэй байх
- 25-45 бар даралтаар эрлифт хийх хүчин чадалтай хийн компрессортой байх
- Гүний худгийн шүүрийн цувааг цэвэрлэх зориулалтын тоног төхөөрөмжтэй байх /гидроерш г.м/

## 3. Шаардагдах баримт бичиг:

### 3.1 Гүйцэтгэх ажлууд, ажил үйлчилгээний үе шатны хуваарь

- **Худгийн байгууламжийг бэлтгэх:** Худгийн байгууламж нь битүү сэндвичэн хавтангаар хийгдсэн бөгөөд худгийг цэвэрлэхийн өмнө шаардлагатай хэсгүүдийг салган авч ажил дууссаны дараа анх байсан хэлбэрт нь оруулж битүүмжлэнэ
- **Шахуургыг гаргах:** Худагт суулгасан ус өргөх шахуургыг краны тусламжтайгаар өргөж сугалах
- **Эрлифтийн шавхалт хийх:** Хийн компрессорын хоолойг худгийн ёроол хүртэл суулгаж худгийн усыг тунгалаг болтол үлээлгэнэ
- **Шүүрийн цувааг цэвэрлэх:** Шүүр суулгасан интервал бүрт гидроершийг ашиглан дээрээс доош цэвэрлэнэ. Үүний дараа худгийн ус өргөх шахуургыг буцаан суурилуулна
- **Ажил гүйцэтгэх хугацаа:** Ажлын даалгавар авснаас хойш 7 хоног

### 3.2 Нийлүүлэгчээс шаардах тусгай зөвшөөрөл, стандартыг тогтоосон тусгай сертификат, бусад баримт бичгийн жагсаалт

- Гүний худаг өрөмдөх, тоноглох, засвар үйлчилгээ хийх мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлтэй байх

### 3.3 Энэхүү ажил үйлчилгээ, бараа материалыг авснаар гарах эдийн засгийн тооцоо болон судалгаа үр ашигтай байдлын талаарх мэдээлэл

- Худгийн усны гарцыг нэмэгдүүлснээр ажилчдын хотхоны ахуйн хэрэглээний усны тодорхой хувийг хангаж, усны машины рейсийг багасгана

3.4 Тухайн бараа материал, ажил, үйлчилгээнд шаардагдах захиалагчийн зүгээс зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг болон нэмэлт шаардлагатай зүйлсийн талаарх мэдээлэл

- Шаардлагатай тохиолдолд ус өргөх хоолойг солих
  - Худагт засвар үйлчилгээ хийж дууссаны дараа акт үйлдэн хүлээлгэж өгөх
4. Гүний худгийн паспортны хуулбарыг эх хувиар хавсаргав.

<p>Сум, дүүрэг, хороо ..... <i>Чоготчанчийн сумын Чагаах бесс баг</i>          Эзэмшигч иргэн, байгууллагын нэр ..... <i>Эрдэнэж Мөнхжин ЦК</i>          Өрөмдмөл худгийн .....</p> <p>Улсын № <i>140501114</i>          Байршиж буй газрын нэр, хаяг .....</p> <p>Ус ашиглах гэрээний № .....</p> <p>Ус ашиглах эрхийн бичгийн № .....</p> <p>Худаг гаргасан (ажлахийн нэгж) ..... <i>21.07. ХХХХ</i></p> <p></p> <p>Захирал ..... <i>М.Ч.Чурганов</i>          20.12 он 12 сар 25 өдөр</p> <p>Баталгаажуулсан.  <i>Одийн Ч.Чурганов</i> (аймаг (нийслэл)-ын Байгаль срчны албаны          тамга</p> <p>Дарга ..... <i>О.С.С.Чурганов</i>          20.12 он 12 сар 25 өдөр</p>	<p><b>Худгийн байршлын солбилцол</b></p> <p>Уртраг: <i>535 229.000</i>          Өргөрөг: <i>48 893.25.000</i>          Үнэмлэхүй өндөр: ..... M,</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: left;">Аймгийн код</th> <th style="text-align: left;">Сумын код</th> <th style="text-align: left;">Худгийн зориулалтын код</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center;"><i>10000</i></td> <td style="text-align: center;"><i>044</i></td> <td style="text-align: center;"><i>140501114</i></td> </tr> </tbody> </table> <p><i>Одийн Ч.Чурганов</i> аймгийн, хотын <i>Чагаах бесс</i> сумын дүүргийн, хорооны, багшийн ..... гэдэг газарт, ..... <i>Чагаах бесс</i> ..... д зориулан <i>45</i> ..... аймгийн, (хотын) ..... <i>21.07.</i> компаний <i>баталгаажуулсан</i> менежер ахлагчтай анги, бригад <i>Баталгаажуулсан</i> маркийн станкоор <i>аргаас, хамгийн чөхжилт</i> ..... аргаар Уул худгийн цооногийг 20.12. он 12 сарын 25 өдөрээс 20.12. он 12 сарын 26 өдөр хүртэл өрөмдж гаргав.</p>	Аймгийн код	Сумын код	Худгийн зориулалтын код	<i>10000</i>	<i>044</i>	<i>140501114</i>
Аймгийн код	Сумын код	Худгийн зориулалтын код					
<i>10000</i>	<i>044</i>	<i>140501114</i>					

<p><b>I. ЦООНГОГИЙН БҮТЭЦ ЗОХИОМЖ</b></p> <p>1. Цооногийн гүн ..... <i>10.5</i> M</p> <p>2. Усны тогтсон түвшин (статик) ..... <i>12</i> M</p> <p>3. Цооногийн ашиглалтын усны ундарга ..... <i>1.0</i> M</p> <p>4. Цооногийн өрөмдсөн диаметр ..... <i>9.0</i> M-зэс <i>10.5</i> M хүртэл ..... <i>2.73</i> MM</p> <p>..... <i>8.0</i> M-зэс <i>10.5</i> M хүртэл ..... <i>1.68</i> MM</p> <p>..... M-зэс ..... M хүртэл ..... MM</p> <p>5. Уст үеийн байрлал:</p> <p>Нэгдүгээр үе ..... <i>3.2</i> M-зэс ..... <i>3.6</i> M</p> <p>Хоёрдугаар үе ..... <i>5.7</i> M-зэс ..... <i>6.1</i> M</p> <p>Гуравдугаар үе ..... M-зэс ..... M</p> <p>6. Цооногийн бэхэлсэн суултын яндан</p> <p>диаметр= <i>1.73</i> MM ..... <i>9.0</i> M-зэс ..... <i>4</i> M</p> <p>диаметр= <i>1.68</i> MM ..... <i>8.0</i> M-зэс ..... <i>10.5</i> M</p> <p>диаметр= ..... MM ..... M-зэс ..... M</p> <p>7. Шүүрийн хийц зохиож:</p> <p>Шүүрийн яндангийн нүхний диаметр ..... MM</p> <p>1 уртааш M-т оногдох нүхний тоо ..... ширхэг</p> <p>Шүүрийн диаметр ..... MM</p> <p>Шүүрийг ороосон утасны диаметр ..... MM</p> <p>Шүүрийг ороосон торны ..... MM</p> <p>Шүүрийн яндангийн нийт урт ..... MM</p>	<p>Унд:</p> <p>Шүүрийн дээд хэсгийн урт ..... <i>6</i> M ..... <i>5.2</i> M-зэс ..... <i>3.9</i> M</p> <p>Ажлын хэсгийн урт ..... <i>6</i> M ..... <i>5.2</i> M-зэс ..... <i>5.8</i> M</p> <p>Дүлий хэсгийн урт ..... M ..... M-зэс ..... M</p> <p>Ажлын хэсгийн урт ..... M ..... M-зэс ..... M</p> <p>Дүлий хэсгийн урт ..... M ..... M-зэс ..... M</p> <p>Тунгаагчийн урт ..... M ..... M-зэс ..... M</p> <p>8. Яндангийн араар дүүргэсэн хайрга</p> <p>9. Цооногт ..... <i>6.0</i> M-зэс ..... <i>10.5</i> M хүртэл ..... M-зэс ..... M</p> <p>хүртэл</p> <p>Цементац (тампонаж) хийв.</p> <p>10. Шавхалтыг 20... он ... сарын .... өдрийн .... цагаас ... сарын .... өдрийн .... цаг хүртэл ..... цаг хийв.</p> <p>Шавхалтыг ..... маркын насосаар ..... M</p> <p>гүнд насосы суулгаж <i>Холимон</i> <i>900/850</i> ... маркын компрессороор ..... M ус өргүүр янданг ..... M</p> <p>гүнд суулгаж ..... M хий дамжуулах янданг ..... M</p> <p>усны түвшин хэмжигч янданг ..... M</p> <p>гүнд тус тус суулгаж гүйцэтгэв.</p> <p>Шавхалт хийхэд усны</p> <p>I. Түвшин бууралт ..... <i>6</i> метр ундарга ..... M/c</p> <p>II. Түвшин бууралт ..... <i>6</i> метр ундарга ..... M/c</p> <p>III. Түвшин бууралт ..... <i>6</i> метр ундарга ..... M/c</p> <p>тус тус байв.</p>
---	--

## II. ЦООНГОЙН ЗҮСЭЛТ

## II. ЦООНГОЙН ЗҮСЭЛТ

- ## 1. Шинжилгээ хийсэн он, сар, өдөр

Үзүүлэлтүүд	Уст үеийн № ба интервал		
	№ .....M	№ .....M	№ .....M
Дээж авсан			
Лабораторт өгсөн			

## 2. Физикийн шинж чанар:

Үзүүлэлтүүд	Уст үеийн № ба интервал		
	№ .....м	№ .....м	№ .....м
Өнгө			
Үнэр			
Амт			
Тунгалаг чанвар			
Тунадас			
Булингэр			
Тэмператур Ԑ.			

### 3. Химиийн найрлага:

Үзүүлэлтүүд	Нэгж хэмжээ	Уст үеийн № ба интервал		
		№ .....M	№ .....M	№ .....M
РН (идэвхит урвал)				
CO <sup>2</sup> (чөлөөт)	мг/л			
CO <sup>2</sup> (турэмийн)	"			
H <sup>2</sup> S (хүхэрт устэреч)	"			
SiO <sup>2</sup> (Цахуурин хөхт ижил)	т <sub>h</sub>			
Исалдах чанар O <sup>2</sup>	"			
Хуурай үлдэгдэл 180°C	"			
Ерөнхий хатуу	мг, экв/л			
Арилгах хатуу				
Тогтолцой хатуу				

#### IV. ХУДГИЙН БАРИЛГА ТӨХӨӨРӨМЖ

1. Худагт ~~205.8 - 6 - 6.5-125~~ маркын усергеч, маркын хөдөлгүүр тавив.  
 Насосыг 9.7 м гүнд байрлуулав.  
 Ус өргөгч яндангийн диаметр 50 мм, урт нь 9 м  
 Насосын штангийн диаметр 50 мм, урт нь 27 м  
 Ус өргөгч төхөөрөмжийг угсарсны дараа 4 цаг зүгшруүлэх шавхалт хийхэд усны ундарга 1.5 л/сек болов.

2. Насос станцын барилгын нийт талбай ..... M<sup>2</sup>

3. Усны резервуарын багтаамж ..... M<sup>3</sup>  
 хийсэн материал .....

5. ХУДГИЙН ӨРТӨГ

1. Эрэмдлэгийн үнэ ..... төгрөг
  2. Насос станцын барилгын үнэ ..... төгрөг
  3. Тоног төхөөрөмжийн үнэ ..... төгрөг

Бурл  
тер

Өрөмдмөл худгийг 20.... оны .... сарын .... өдөр ..... тоот  
актаар комиссын дарга ..... пишууд  
.....нарын  
бүрэлдэхүүнтэй комисс ..... иргэн, компани, байгууллагын  
нэрийн өмнөөс ашиглалтад хүлээнцүүлэв.

## Тав. ЗУРАГ

### Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

### Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

#### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

##### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарыг заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарыг хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарыг заавал оруулна.

##### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

##### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыг заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыг зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(*Захиалагч байгууллагын нэр*)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [*тендерт оролцогчийн нэр*], [*гэрээний нэр ба дугаар*]-ыг [*тендерийн үнийг тоогоор болон үсгээр*] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүргэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

	9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
<b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b>	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
<b>В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ</b>	
<b>11. Үе шатны ажлын хуваарь</b>	11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарыт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
<b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b>	11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
<b>13. Алданги</b>	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарыт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
<b>Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ</b>	
<b>14. Ажил дуусгах</b>	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
<b>15. Хүлээж авах</b>	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
<b>16. Эцсийн тооцоо</b>	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
<b>ДАЧИДААНЫН СОХИМЧИЙН НАРИЙВЧИЛСАН ТООЦОО</b>	
<b>17. Гүйцэтгэгчийн тооцоо</b>	
17.1. Гүйцэтгэгчийн тооцоо төслийн менежерийн зорилтуудад хувь хэмжээгээр хүлээн авсан тухай мэдэгдэл гаргаж, чанаарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.	
17.2. Гүйцэтгэгчийн тооцоо төслийн менежерийн зорилтуудад хувь хэмжээгээр хүлээн авсан тухай мэдэгдэл гаргаж, чанаарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.	

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлаг**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстай төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах,

хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>Уурхайн ашиглалтын худгуудад засвар үйлчилгээ хийх гүйцэтгэгчийг сонгох харьцуулалтын тендер, Дугаар: ЭТТ/201901208</b>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>[төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хурээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <b>Өмнөговь аймаг Цогтицэний сумын сум “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Уурхай</b>
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяз]</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> <sup>3</sup>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын <i>[3]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>[1 жил]</i> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[0,5хувь]</i> байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.  Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[10 хувь]</i> -иар тооцно.

<sup>3</sup> Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]